

Бүлэг сэдэв	Ажлын хуудасны нэр	Ажлын хуудасны дугаар	Танин мэдэхүйн түвшин		
			I	II	III
Дүрслэн тайлбарласан эх	Дүрслэн тайлбарласан эхийн сэдэв, гол санааг тодорхойлж	2			
	Дүрслэн тайлбарласан эхээс уран дүрслэлийг ялгаж тайлбарлая	3			
	Дүрслэн тайлбарласан эхээс хэлцийг ялган, тайлбарлая	4-5			
	Тайлбарлан бичихдээ хэлц ашиглая	6			
	Бүлэг сэдвийн үнэлгээ	7			
Тоочин тайлбарласан эх	Тоочин тайлбарласан эхийн агуулгыг ойлгоё	8			
	Эх дэх баримт мэдээллийг шинжилж.	9-10			
	Тоочин тайлбарлаж бичье	11			
	Бүлэг сэдвийн үнэлгээ	12			
Учир шалтгааныг тайлбарласан өргөдөл	Өргөдлийн утгыг ойлгоё	13			
	Өргөдлийн бүтцийг задлан шинжилж	14			
	Өргөдлийн хэл, найруулгын онцлогийг судалъя	15			
	Өргөдөл бичье	16-17			
Найруулгын алдааг таньж, тодорхойлж		18			
Баримт мэдээллийг харьцуулах	Баримт дүрслэлийг ялгах	19-20			
	Баримт мэдээллийг харьцуулж унших	21-22			
	Баримт мэдээллийг харьцуулж дүгнэх	23-25			
Учир шалтгааныг тайлбарлах	Учир шалтгааныг тайлбарласан зөвлөгөө бичье	26			
	Угсарсан нийлмэл үгийг таньж найруулгын үүргийг тодорхойлж	27			
	Шалтгааны утгат угсарсан нийлмэл өгүүлбэрийг ойлгож, хэрэглэж	28-31			
	Учир шалтгааныг тайлбарлах мэдлэг ойлголтоо бататгая.	32			

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр... цаг



Эхийн сэдэв: Эхэд өгүүлэгдэж байгаа гол юмнаас үүдэлтэй санааг сэдэв гэнэ. Юуны тухай? гэсэн асуултаар илрүүлнэ. **Эхэд дэвшүүлсэн асуудал:** Тухайн сэдвийн хүрээнд илэрч буй шийдвэрлэх шаардлагатай асуудлыг хэлнэ. **Эхийн гол санаа:** Сэдэв болон дэвшүүлсэн асуудлын хүрээнд гаргасан дүгнэлт санааг хэлнэ. **Түлхүүр үг:** Эхэд олон давтагдаж орсон, гарч буй хэрэг явдлын санааг бүтээхэд чухал үүрэгтэй үгийг хэлнэ.

Залхууг зайлуулъя

... Хүний амьдралын дотоод дайснууд дотроос адгийн хорлогч нь залхуурал билээ. Гадаа хэвтсэн төмөр дотроо зүгээр байвч гаднаасаа зэвэнд идэгддэг бол залхуурч хэвтсэн бие гаднаа зүгээр мэт байвч дотроосоо зэвэнд баригддаг юм.

...Залхуурал авьяас билгийг хөгжүүлэхэд хамгийн том саад тотгор, амжилт ололтыг ахиулахад хамгийн адгийн тээг билээ. Сурч мэдэхэд тархи багласан чөдөр тушаа, судалж танихад замд тээглэсэн бул хар чулуу, жаргах замын садаа бол залхуурал. Ажилсаг хүнд залхуучууд нүдэнд орсон хог, шүдэнд тээглэсэн мах адил үзэгдэнэ.

... Залхууг ялж чадвал бараан үүлээ хөөсөн тэнгэр цэлмээд ирэхийн адил барайж байсан амьдрал чинь дэвжээд ирэх баяр жаргалыг үзнэ. (Н.Багабанди “Титэм үг”-ийн хэсгээс)

Дасгал 1. Дүрслэн тайлбарласан эхийн сэдэв, гол санааг тодорхойлъё.

Алхам 1. Өргөдлийг хэнд хандаж бичсэн байна вэ?

.....

Алхам 2. Өргөдлийг хэн бичсэн байна вэ?

.....

Алхам 3. Өргөдлийг бичих болсон шалтгаан нь юу вэ? Хоёр баримт бичээрэй.

1.

2.

Алхам 4. Өргөдлийг ямар зорилгоор бичсэн байна вэ?

.....

Алхам 5. Өргөдөл гаргагч өргөдлийн төгсгөл хэсэгт өөрийн тухай ямар ямар мэдээллийг бичсэн байна вэ?

.....

.....

.....

.....

Дууссан:онсарөдөр... цаг

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр... цаг



Дүрслэн тайлбарлах: Тайлбарлан бичихдээ уншигчийн сонирхлыг татах, элэрхийлж буй санааг улам тодорхой болгох зорилгоор сэтгэл хөдлөлөө илэрсэн төрөл бүрийн уран яруу үг хэллэг, хэлц үг, зүйр цэцэн үг зэрэг дүр дүрслэл ашиглан бичсэн эхийг хэлнэ.

Уран дүрслэл: Зохиогч өгүүлж хэлэх гэсэн санаагаа илүү ойлгомжтой, сонирхолтой яруу тансаг, өвөрмөц илэрхийлэх зорилгоор адилтгал, зүйрлэл, хүншүүлэл, хэтрүүлэл, төлөөлөл эсрэгцүүлэл гэх мэт үгийн утгыг шилжүүлэн дүрслэх аргыг хэрэглэн уран дүрслэл бүтээдэг.

Дасгал 1. Дүрслэн тайлбарласан эхээс уран дүрслэлийг ялган тайлбарлая.

Алхам 1. Эхэд залхуурлыг юутай адилтган дүрсэлсэн байна вэ? Гурван жишээ бич.

Залхуурал бол **адгийн хорлогч**

Залхуурал бол

Залхуурал бол

Залхуурал бол

Алхам 2. Ялгасан уран дүрслэлийнхээ утгыг дараах аргаар тайлбарлая.

1. Дүрсэлсэн үгийн үндсэн утгыг толь бичиг ашиглан тайлбарлана.
2. Эдгээр үгсээр ямар далд утга илэрхийлж байгааг эхийн утгатай холбон тайлбарлана.

Уран дүрслэл	Тайлбар
Залхуурал бол адгийн хорлогч	<ol style="list-style-type: none"> 1. адгийн- хамгийн муу, хамгийн доод, хорлогч- бусдыг хорлох муу санаатай хүн 2. Залхуурч хэвтсэн хүнийг гаднаас нь харахад зүгээр мэт боловч дотроо зэвэнд баригдсан мэт болсон байдаг гэж эхэд бичсэн байна. Тэгэхээр залхуурал бол хүний хийж бүтээх хөгжих боломжийг хааж устгадаг учраас хорлогч гэж адилтган хүншүүлсэн байна.
.....	<ol style="list-style-type: none"> 1. 2.
.....	<ol style="list-style-type: none"> 1. 2.
.....	<ol style="list-style-type: none"> 1. 2.

Алхам 3. Дараах хэсэгт “залхуугаа ялснаар амьдрал сайжирч, баяр жаргалыг үзнэ” гэдгийг хэрхэн дүрсэлснийг тайлбарлаарай.

Залхууг ялж чадвал бараан үүлээ хөөсөн тэнгэр цэлмээд ирэхийн адил барайж байсан амьдрал чинь дэвжээд ирэх баяр жаргалыг үзнэ.

Тайлбар:

Дууссан:онсарөдөр... цаг

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр... цаг



Хэлцийн онцлог шинж:

- Хоёр ба түүнээс дээш үгээс бүтдэг.
- Уран дүрслэлийн ашиглан далд утга санаа илэрхийлдэг.
- Аль нэг үгийг нь өөр үгээр сольж болохооргүй хэвшсэн.
- Тухайн ард түмний ахуй амьдралтай гүн бат холбоотой

Аавын хүү аашинд дийлдэнэ

Хүн бүхэн өөрийн гэсэн ааш авиртай. Юм бүхэнд хэмжээ дамжаа хэрэгтэй. (1) Илүүдсэн бүхэн хор болдгийн адил ааш хэтэрвэл амьдралд цөвтэй. Ааш авираа өөрөө захирах учиртай. Хэрээс хэтэрсэн аашиндаа хүн өөрөө дийлдэн хүлээ баглаатай зовно. Хүний түлхүүрээр өөрийн хаалгыг онгойлгож болдоггүйтэй адил өөрийн аашаар өрөөлийг захирах амаргүй. Илүү дутуу ааш араншингүй хүнтэй эвлэж зохицох амархан. Олон ааштай хүнтэй ойртон нөхөрлөх хэцүү. Сайхан ааштай мөртлөө саар мууг сэдэгчид бий. Муухай ааштай хэрнээ машид сайхныг бүтээгчид бас байна. Авьяас чадвар чамбай хэрнээ аашнаасаа болж алдагсад цөөнгүй. (2) Ааш гэж адасга болсон хүнээс алс холуур дөлж яв. Муухай зантай хүн мундахгүй балгийг тарина. Авиргүй аашлах нөхрөөс амжиж хурдан холд. Бар мэт явснаа хонь мэт номхрох нь барьцгүй аашны шинж. Гайгүй намуухан байснаа галзуу бар шиг авирлах нь гаж аашны тэмдэг. Хорт могой ойроос хатгадаг бол хорон ааштанд хол ойрын ялгаа үгүй. (3)

Шударга үг чихэнд хатуу ч явдалд тустай болохоор анд нөхрийнхөө алдаа оноог алдалгүй хэлж тусал. (4).

Дасгал 1. Эхийн агуулгыг ойлгоё.

Алхам 1. Дараах үгсийн утгын ялгааг толь бичиг ашиглан тайлбарлан бичээрэй.

- Ааш авир
- Ааш араншин.....
- Гаж ааш
- Хорон ааш
- Барьцгүй ааш
- Муухай ааш

Алхам 2. Эх дэх цогцолборуудын санааг зөв дугаарлаарай.

Цогцолборын санаа	Цогцолборын дугаар
Ааш авираа өөрөө удирдан захирах хэрэгтэй.	
Ааш авир муутай хүнээс холуур явах нь дээр	
Хүн бүхэн адилгүй.	
Найз нөхдийнхөө алдаа оноог шударгаар хэлж засахад нь тусал.	

Алхам 3. Зохиогч ямар санааг тайлбарлан ойлгуулахыг зорьсон бэ?

1. Хүн болгон адилгүй гэдгийг тайлбарласан.
2. Хүн аашнаасаа болж алддаг гэдгийг тайлбарласан.
3. Ааштай хүнээс холуур явсан нь дээр гэдгийг тайлбарласан.
4. Хүний аашинд нь тохируулж харьцах хэрэгтэй гэдгийг тайлбарласан.

Дууссан:онсарөдөр... цаг

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр... цаг

Дасгал 2. Зохиогчийн дүрслэн тайлбарлахдаа ашигласан аргыг судалъя.

Алхам 1. Дараах өгүүлбэрүүдэд тодруулсан үгсийн өмнөх хойдох өгүүлбэрүүд ямар утгатай байна вэ? Тайлбарлаж бичээрэй.

1. Муухай ааштай **хэрнээ** машид сайхныг бүтээгчид бас байна.

.....

2. Сайхан ааштай **мөртлөө** саар мууг сэдэгчид бий.

.....

3. Бар мэт явснаа хонь мэт номхрох нь барьцгүй аашны шинж

.....

Алхам 2. Дээрх өгүүлбэртэй адил аргаар бүтсэн 2 жишээ эхээс олж бичээрэй.

1.

2.

Дасгал 3. Тайлбарлахдаа хэлц ашигласан аргыг судалъя.

Алхам 1. Зохиогч өөрийн санаа бодлыг илэрхийлэхдээ ямар ямар хэлц ашигласан байна вэ? Эхээс 3 жишээ түүж бичээрэй.

хэрээс хэтрэх

Алхам 2. Түүж бичсэн хэлцийнхээ утгыг дараах аргачлалын дагуу тайлбарлаарай.

1. Хэлц дэх үг бүрийн үндсэн утгыг толь бичиг ашиглан тайлбарлана.
 2. Эдгээр үгсээр ямар далд утга илэрхийлж байгааг эхийн утгатай холбон тайлбарлана. Хэрээс хэтрэх: 1. **хэр**- хэмжээ, чадал чинээ, **хэтрэх**- давах, илүү гарах гэсэн утгатай. 2. Байвал зохих хэмжээнээс хэтэрсэн ааш муутай гэсэн утга илтгэж байна.

2.

3.

4.

Алхам 3. Дараах хоёр өгүүлбэрийг харьцуулаад хэлц ашиглан санаагаа илэрхийлэх нь найруулгад ямар үүрэгтэй болохыг тайлбарлаарай.

№	Хэлц ашиглаж дүрсэлсэн	Энгийн үгээр дүрсэлсэн
1	Ааш гэж адасга болсон хүнээс алс холуур дөлж яв.	Хэтэрхий муухай ааштай хүнээс алс холуур дөлж яв.
2	Бар мэт явснаа хонь мэт номхрох нь барьцгүй аашны шинж.	Догшин ширүүн байснаа номхон дөлгөөн болох нь барьцгүй аашны шинж.

Алхам 4. Аль өгүүлбэр нь уншихад илүү сонирхолтой, уран яруу байна вэ? Яагаад?

.....

.....

.....

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр... цаг
 Хамгийн сайн найзаа танилцуулан бичээрэй.
 Бичихдээ хэлц болон уран дүрслэлийг ашиглаарай. Зохион бичлэгээ нэрлэхдээ найзынхаа хамгийн онцлог шинжийг хэлцээр илэрхийлээрэй.
 Бичихдээ 5-аас доошгүй хэлц ашиглаарай. Дараах хэлцээс тохирохыг сонгон ашиглаж болно

<p>Баярлах: инээд ханиад болох, нар нь гарах, Бүрэг дуугүй: ам чангатай, ус балгасан юм шиг, Аядуу: Нүдэнд дулаахан, Даврах: гар бариад бугуй барих, толгой дээр гарах Хөдөлгөөнтэй: өрөмний өт шиг</p>	<p>Дотно: зүү орох зайгүй, гал хам Сэргэлэн, овжин: гүйлгээ ухаантай, од шүүрэх Ховор: нүдний гэм, хорвоод хосгүй Буурь суурьтай: ноён нуруутай</p>
--	--

..... найз минь

Найзынхаа нэр, хаана яаж танилцсан тухай, анх харахад ямар сэтгэгдэл төрсөн бэ?

.....

.....

.....

Найз чинь ямар дүр төрх, зан чанартай вэ? Ямар зан чанараар нь бахархдаг вэ? (хэлц ашиглан дүрслээрэй)

.....

.....

.....

.....

.....

Яагаад хамгийн сайн найзаа гэж бодох болсон бэ? Тайлбарлаарай.

.....

.....

.....

.....

Цаашид нөхөрлөлөө хэрхэн үргэлжлүүлэх, найзтайгаа хамтдаа юу хийхийг хүсдэг талаараа чин сэтгэлийн үгээ бичээрэй.

.....

.....

.....

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр... цаг

Хөхөө өвлийн хүйтэнд, хөр цасны жаварт Монголчууд өвлийн гурван сарыг хүйтрэх, хөр цас унах байдлаар нь гурав гурван есэд хувааж есөн есийн наян нэгэн хоногийн хүйтэн болдог гэж үзнэ.

12-р сарын 22-оос ес эхэлнэ.Эхний гурван есийг балчир, дундхыг идэр, сүүлийнхийг хөгшин гурван ес гэдэг. Энэ нь хүний насаар бол бага, залуу, өтөл үетэй зүйрлэсэн нэр юм. Идэр есийн хүйтэнд гунан үхрийн эвэр хөлдтөл хүйтэрдэг. Энэ үеийг цаг тооны хуучин тооллоор “Хөхөө сар” гэдэг ажээ. Өвөл хөхөө байхгүй атал “Хөхөө өвөл” гэж хэлдэг нь үүнээс улбаатай бөгөөд улмаар “Хөхөө өвлийн хүйтэнд, хөр цасны жаварт” гэсэн хэлц үг дэлгэрсэн байна.

Үүнтэй холбоотой “Хөхөөг хүйдсээр цохих” гэсэн огтоос бүтэхгүй юмыг зүйрлэн хэлсэн гол санаатай хэлц буй болсон. Анх үүдсэн нь өвөл хөхөө шувуу үзэгдэхгүй; хүйдэс (малын хөлдүү баас) зөвхөн өвлийн хүйтэнд байдаг. Тэгэхээр хөхөөг хүйдсээр цохих гэдэг бодит байдалд байх боломжгүй зүйл болно.

Үүнтэй ойролцоо утгатай “харганы ноос түүж эсгий хийх”, “нар баруун хойноос гарах”, “зангууны үлгэр”, “аалзны шүлсээр гөлөм гөрөх” зэрэг хэлц бий.

(Д.Баттогтох “Үлгэрээс үүдсэн хэлцийн толь”-оос)

Алхам 1. Эхэд юуг, яаж тайлбарласныг цогцолбор бүрээр тодорхойлъё.

Бүтэц	Юуг тайлбарласан бэ?	Яаж тайлбарласан бэ?
Эхлэл хэсэг		
Гол хэсэг		
Төгсгөл хэсэг		

Алхам 2. “Хөхөө өвлийн хүйтэнд, хөр цасны жаварт” гэдэг үгийн утгыг зохиолч юу гэж тайлбарласан байна вэ?

.....

Алхам 3. Дараах дүрслэлийн утгыг тайлбарлаарай.

Балчир гурван ес:

Идэр гурван ес:

Хөгшин гурван ес:

Алхам 4. “Хөхөөг хүйдсээр цохих” гэдэг хэлц үгийн утгыг зохиолч хэрхэн тайлбарласан байна вэ?

.....

Алхам 5. Дараах хэлцүүдэд “Огтоос бүтэхгүй зүйл” гэдгийг хэрхэн зүйрлэснийг тайлбарлаарай.

1. “харганы ноос түүж эсгий хийх”

2. “нар баруун хойноос гарах”

3. “зангууны үлгэр”

4. “аалзны шүлсээр гөлөм гөрөх”

.....

.....

.....

Алхам 6. Дээрх эхэд ашигласан дүрслэл хэлцүүд ямар үүрэгтэй орсныг дүгнэн бичээрэй.

.....

.....

.....

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр... цаг

Дасгал 1. Тоочин тайлбарласан эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог ялган танья.

Монгол бөхөн

Монгол бөхөн нь буган биетэй, тэмээн толгойтой монгол хонины хэрийн биетэй ургамлан тэжээлт, хивэгч амьтан. Биеийн урт 100-145 см, сэрвээний өндөр 63-83 см, сүүл 8-13 см, чихний урт 7.5-11 см, жин 23-40кг хүрнэ. Хөл, хүзүү нарийн, толгой том, өвөрмөц монхор хамартай, хамрын нүх маш том. Хэрэгчин мухар, хэржин 40 см хүрэх тунгалаг цайвар өнгөтэй хос шоорон эвэртэй, эврийн цагирагт одорохой харагдана. Биеийн өнгө зуны улиралд бор шаргал байснаа өвөл болоход цайвар саарал болж өөрчлөгдөнө. Сэрвээнээс сүүлний уг хүртэл зоо дагасан нарийхан бор судалтай, хэвэл, гуяны дотор тал цайвар өнгөтэй.

Бөхөн нь Евроазийн том хөхтөн амьтдын дотроос устгах аюулд нэлээд өртөөд байгаа зүйлийн нэг. Дэлхий дээр соргог бөхөн (*Saiga tatarica tatarica*), монгол бөхөн (*Saiga tatarica mongolica*) гэх хоёр салбар зүйлийн бөхөн бий. Эдгээр дэд зүйл нь амьдрах орчны хуваагдал, хууль бус агнуур, гэрийн малтай бэлчээр, тархац нутгаар давхцах зэрэг шалтгааны улмаас 2 популяцын тоо толгой сүүлийн 20 гаруй жил (1980-2000)-ийн дотор 1 саяас 90,000 болтлоо огцом буурсан байна (E.J.Milner-Gullard нар 2001).

Монгол бөхөнг манай улсын төдийгүй олон улсын байгаль хамгааллын холбоод анхааралдаа авсаар ирсэн. Тухайлбал: Дэлхийн байгаль, байгалийн нөөцийг хамгаалах олон улсын холбооноос (IUCN, 2002) гаргасан улаан номонд эмзэг гэсэн категорит, Зэрлэг амьтан, ургамлын ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай олон улсын конвенцийн (Вашингтоны, CITES 1975, 1994) II хавсралт буюу хатуу чанд хяналтан дор худалдаалах амьтдын жагсаалтад, дэлхийн ховордсон 100 амьтны жагсаалтад тус тус бүртгэгдсэн. Монгол улсын хэмжээнд 1930 оноос эхлэн хуулиар агнахыг хориглон дархан цаазтай амьтны тоонд оруулсан, Монгол улсын “Улаан ном”-ын 1987, 1997 оны хэвлэл, 1995 оны шинэчлэн найруулсан “Амьтны аймгийн тухай хууль”-аар нэн ховор ангилалд оруулсан.

Үгийн утгын тайлбар: *Хэрэгчин:* Эмэгчин бөхөн *хэржин:* эр бөхөн

Алхам1. Эхний цогцолборыг уншаад Монгол бөхөнгийн зургийг сонгоорой.


А.

Б.

В.



Алхам 2. Хоёрдахь цогцолбороос бөхөнгийн ховордсон шалтгааныг бичээрэй.



Алхам 3. Төгсгөлийн цогцолборт юуны тухай өгүүлсэн байна вэ?

.....
.....

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр... цаг



Бодит амьдралд туршлагаар батлагдсан бүхэн баримт болно. Баримт заавал үнэн байх ёстой. Болсон үйл явдал, үзэгдэл, юмс, тоон үзүүлэлт, тодорхойлолт, эшлэл, жишээ зэргийг баримт гэж үзэж болно.

Дасгал 2. Эх дэх баримт мэдээллийг задлан шинжилье.

Алхам 1. Хүснэгтэд цогцолбор бүрд юуг , яаж, ямар аргаар тайлбарласныг тодорхойлж бичээрэй.

Юуг тайлбарласан байна вэ?	Яаж тайлбарласан байна вэ?	Ямар арга ашигласан байна вэ?
<p>1-р цогцолборт</p> <p>Монгол бөхөнгийн биеийн онцлог</p>	<p>Биеийн харагдах байдал:</p> <ul style="list-style-type: none"> • Буган биетэй • Тэмээн толгойтой • Монгол хонины хэрийн биетэй • Хөл, хүзүү нарийн, толгой том, • Өвөрмөц монхор хамартай, хамрын нүх маш том <p>Биеийн хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> • Биеийн урт 100-145 см, сэрвээний өндөр 63-83 см, сүүл 8-13 см, чихний урт 7.5-11 см, жин 23-40кг хүрнэ. <p>Эвэр:</p> <ul style="list-style-type: none"> • Хэрэгчин мухар, хэржин 40 см хүрэх тунгалаг цайвар өнгөтэй хос шоорон эвэртэй, эврийн цагирагт одорохой харагдана. <p>Өнгө</p> <ul style="list-style-type: none"> • Биеийн өнгө зуны улиралд бор шаргал байснаа өвөл болоход цайвар саарал болж өөрчлөгдөнө. Сэрвээнээс сүүлний уг хүртэл зоо дагасан нарийхан бор судалтай, хэвэл, гуяны дотор тал цайвар өнгөтэй. <p>Идэш тэжээл:</p> <ul style="list-style-type: none"> • ургамлан тэжээлт, хивэгч амьтан. 	<p>Монгол бөхөнгийн онцлогийг тоочин тайлбарласан байна.</p>
<p>2-р цогцолборт:</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>	<ul style="list-style-type: none"> • Бөхөнгийн төрөл: 1. 2. <ul style="list-style-type: none"> • Тоо толгой нь буурсан шалтгаан: 1. 2. 3. 	<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
<p>3-р цогцолборт:</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>	<p>1.</p> <p>2.</p> <p>3.</p> <p>4.</p>	<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр... цаг



Эшлэл: Зохиол, өгүүллээс баримт болгон авсан оруулга

Судалгаа: Аливаа юмны зүй тогтлын учрыг олох үйл ажиллагаа, судлах

ажиллагаа. **Тоон үзүүлэлт:** Тоон үр дүн. **Тодорхойлолт:** Юм үзэгдлийн

шинж чанар, бүтэц бүрэлдэхүүн, ач тус зэргийг тоочсон бичвэр. **Үнэлэлт дүгнэлт:** Юмны үр дүн, үнэ цэнийг хураангуйлан тодорхойлж гаргасан нь. **Бодит байдал:** Юмсын одоо байгаа бодит үр дүн.

Дасгал 3. Эхэд дурдсан баримт мэдээллийг ангилъя.

Алхам 1. Дараах баримтуудыг төрөлтэй нь зөв харгалзуулаарай.

1. Бодит байдал

2. Үнэлэлт дүгнэлт

3. Судалгаа

4. Тоон үзүүлэлт

5. Тодорхойлолт

6. Эшлэл

А. Монгол бөхөн нь буган биетэй, тэмээн толгойтой монгол хонины хэрийн биетэй ургамлан тэжээлт, хивэгч амьтан.

Б. Дэлхийн ховордсон 100 амьтны жагсаалтад бүртгэгдсэн.

В. 2 популяцын тоо толгой сүүлийн 20 гаруй жил (1980-2000)-ийн дотор 1 саяас 90,000 болтлоо огцом буурсан байна (E.J.Milner-Gullard нар 2001).

Г.Бөхөн нь Евроазийн том хөхтөн амьтдын дотроос устах аюулд нэлээд өртөөд байгаа зүйлийн нэг.

Д. Монгол улсын “Улаан ном”-ын 1987, 1997 оны хэвлэл, 1995 оны шинэчлэн найруулсан “Амьтны аймгийн тухай хууль”-аар нэн ховор ангилалд оруулсан.

Е. Дэлхийн байгаль, байгалийн нөөцийг хамгаалах олон улсын холбооноос (IUCN, 2002) гаргасан улаан номонд эмзэг гэсэн категорит орсон.

Алхам 2. Эхээс 3 баримт сонгож баримтын ямар төрөл болохыг тодорхойлоорой.

№	Баримт	Төрөл
1.		
2.		
3.		

Алхам 3. Тоочин тайлбарлаж бичихэд баримт ямар үүрэгтэй вэ? Эхээс баримтыг нь хасвал ямар болох бол? Дүгнэн бичээрэй.

.....

.....

.....

.....

.....

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр... цаг



Мэдээлэн тайлбарлаж бичих: Тухайн сэдвийн талаар уншигчид тодорхой мэдээлэл өгөхийг гол зорилгоо болгодог. Бичсэн сэдвийнхээ талаар итгүүлж үнэмшүүлэхээс илүү тайлбарлан таниулахыг чухалчилдаг.

Мэдээлэн тайлбарлахдаа бодит байдал, тодорхой баримт мэдээллүүдийг тоочин бүлэглэж бичих нь элбэг. Тэгдэг, ингэдэг, тийм байна, ийм байна гэсэн өнгө аясаар өгүүлбэрүүд нь төгсдөг.

Дасгал 1. Амьтны тухай мэдээлэн тайлбарлаж бичье.

1. Өөрийн хайртай, эсвэл хамгийн сайн мэдэх амьтныг сонгоорой.
2. Сонгосон амьтнаа дараах бүтцийн дагуу мэдээлж тайлбарлаж бичээрэй. Өөрийн мэдлэгээ баяжуулан ном, сонин, интернэт, ойр дотны хүмүүс баримт цуглуулж бичээрэй.

Амьтны нэр.....

Ерөнхий мэдээлэл: ямар овгийн амьтан болох. Эр, эм, үр төлийг нь юу гэж нэрлэдэг вэ?

.....
.....
.....

Гадаад төрх нь ямархуу харагддаг талаар нүдэнд харагдтал дүрслээрэй.

.....
.....
.....
.....

Хаагуур нутагладаг, ямар орчинд амьдардаг вэ?

.....
.....
.....
.....

Хоол тэжээл.....

.....
.....
.....

Холбоотой сонирхолтой баримт:

.....
.....
.....
.....

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр... цаг

Монголын хамгийн жижиг ном

1984 онд академич Ц.Дамдинсүрэн эрдэмтэн Шагжийн бичсэн нэгэн сонин номыг улсын нийтийн номын санд өгчээ.

Уг ном нь 5,5 см тэг дөрвөлжин цаасан дээр түвдээр бичсэн Дол-дод буюу ногоон дарь эхийн магтаал юм. 5x5,5 см цаасан дээр, 5x 4,7 см талбайд багтаан бичжээ. Тэр бяцхан номыг энгийн нүдээр харахад ер мэдэгдэх аргагүй, нэг эрээн цаас шиг юм үзэгдэх бөгөөд харин давхар линзтэй шил буюу микросопоор хараад уншиж болох ажээ.



Түүнийг эрдэмтэн Шагж хялгасны үзүүрээр бичсэн маш өвөрмөц, онцгой нарийн ур шаардсан бүтээл ажээ.

Алхам 1. Эхэд юуны тухай тайлбарласан байна вэ?

.....

Алхам 2. Эрдэмтний зохиосон энэ ном бусад номоос юугаараа онцлог вэ?

.....

.....

Алхам 3. Эхэд байгаа баримтуудыг түүж бичээд баримтын ямар төрөл болохыг нэрлээрэй.

№	Баримт	Төрөл
1		
2		
3		
4		

Алхам 4. Дээрх эхэд “Монголын хамгийн жижиг ном”-ын тухай баримтуудыг тоочихдоо өгүүлбэрүүдийг хэрхэн төгсгөсөн байна. вэ? Түүж бичээд утгыг тайлбарлаарай.

.....

.....

.....

Алхам 5. Дээрх эхийн зорилго юу вэ?

1. “Монголын хамгийн жижиг ном” бол үнэхээр гайхамшигт бүтээл юм гэж итгүүлсэн.
2. “Монголын хамгийн жижиг ном”-ын тухай мэдээлэн тайлбарласан.
3. “Монголын хамгийн жижиг ном”-хэрхэн бүтсэн үйл явцыг хүүрнэсэн.
4. “Монголын хамгийн жижиг ном”-ыг бүтээх хэрэгтэй гэж ятгасан.

--	--	--

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр... цаг



Хувь хүнээс асуудал шийдэх мэдэл бүхий албан газар, албан тушаалтанд хувийн хүсэлтээ бичин, өргөн барьсан албан бичгийг өргөдөл гэнэ.

Дасгал 1. Өргөдлийн утгыг ойлгоё.

“Монголын урлагийн сэтгэл заслын мэргэжлийн холбоо”-нд өргөдөл гаргах учир нь

Батбаатар овогтой Оюу миний бие Нийслэлийн ерөнхий боловсролыг 184 дүгээр сургуулийн 8б ангид сурдаг.

Манай сургуулийн орчимд болон гэрийн ойролцоо хүүхдүүд бие биенээ дээрэлхэх, айлгаж дарамтлах үйлдлүүд гарч байхыг би хэд хэдэн удаа харсан. Бас манай 6 дугаар ангийн дүүг гэртээ харихаар явж байхад нь бүлэг хүүхдүүд дээрэлхэж айлгасан байсан. Түүнээс болоод дүү маань ганцаараа сургуульдаа явах, гадаа тоглохоос айдаг болсон. Би дүүгээ гадуур гарахад нь хамт явахаас өөрөөр яаж туслахаа сайн мэдэхгүй байсан юм. Саяхан танай байгууллагаас “Үе тэнгийнхний дээрэлхэлтийн эсрэг аян”-г эхлүүлж, сургалт зохион байгуулж байгаа талаар уншаад маш их баярлаж, энэ талаар дэлгэрэнгүй мэдэхийг хүсэж байна.

Тиймээс танай байгууллагаас манай сургууль дээр ирж 6-12 дугаар ангийн сурагчдад дээрэлхэлтийг таслан зогсоох талаар сургалт хийж өгөхийг хүсэж байна.

Өргөдөл гаргасан: Нийслэлийн ерөнхий боловсролын 184 дүгээр сургуулийн 8б ангийн сурагч Батбаатар овогтой Оюу.

Утас: 8880****

2021 оны 10 дугаар сарын 12-ны өдөр

Алхам 1. Өргөдлийг хэнд хандаж бичсэн байна вэ?

.....

Алхам 2. Өргөдлийг хэн бичсэн байна вэ?

.....

Алхам 3. Өргөдлийг бичих болсон шалтгаан нь юу вэ? Хоёр баримт бичээрэй.

1.

2.

Алхам 4. Өргөдлийг ямар зорилгоор бичсэн байна вэ?

.....

Алхам 5. Өргөдөл гаргагч өргөдлийн төгсгөл хэсэгт өөрийн тухай ямар ямар мэдээллийг бичсэн байна вэ?

.....

.....

.....

Дууссан:онсарөдөр... цаг



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг



Өргөдлийн эхэнд харилцахыг хүссэн албан газар, албан тушаалтны нэрийн ард “танаа” гээд дараах мөрийг голлуулан “өргөдөл гаргах учир нь” гэж бичсэнийг өргөдлийн толгой гэнэ. Өргөдлийн агуулгын эхлэл хэсэгт өөрийн (өөрсдийн) тухай товч тодорхой танилцуулна. Дараа нь уг өргөдлийг гаргах болсон шалтгаан, түүнд холбогдох баримт мэдээллийг товч танилцуулна. Төгсгөлд юуг хэрхэн шийдүүлэхийг хүсэж байгаагаа бичнэ.

Өргөдлийн дор “өргөдөл гаргасан” гээд ажил, сургууль юмуу гэрийн хаяг, овог нэр, он, сар, өдөр, шаардлагатай бол холбогдох утасны дугаараа бичнэ. Энэ хэсгийг өргөдлийн хөл гэж нэрлэх нь бий.

Дасгал 2. Өргөдлийн, бүтцийг задлан шинжилье.

Алхам 1. Бүтцийн хэсгүүдийг тохирох хэсэгтэй нь холбоно уу.

Эхлэл буюу толгой хэсэг	Өргөдөл гаргагчийн товч танилцуулга
Гол буюу үндсэн хэсэг	Хүлээн авагч байгууллага, албан тушаалтны нэр
	Өргөдөл гаргагчийн хаяг, албан тушаал,
	Өргөдөл бичих болсон шалтгаан, нотлох баримт, мэдээлэл
Төгсгөл буюу хөл хэсэг	Юуг хэрхэн шийдүүлэх гэж буй тухай

Алхам 2. Өргөдлөөс бүтцийн хэсгүүдэд харгалзах жишээг түүж бичээрэй.

Өргөдлийн бүтэц	Бүтцийн хэсэгт тохирох жишээ
Эхлэл буюу толгой хэсэг	“Монголын урлагийн сэтгэл заслын холбоо”-нд өргөдөл гаргах учир нь
Гол буюу үндсэн хэсэг	Эхлэл
	Гол
	Төгсгөл
Төгсгөл буюу хөл хэсэг	

Алхам 3. Өргөдлийг дээрх бүтцээс өөрөөр бичиж болох уу? Яагаад?

.....

.....

--	--	--

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 3. Өргөдлийн хэл, найруулгын онцлогийг задлан шинжилье.

Алхам 1. Өргөдлийг хэддүгээр биеэс бичсэн байна вэ? Зөв хариултыг сонгож, өргөдлөөс жишээ татаж батлаарай.

А. Нэгдүгээр биеэс Б. Хоёрдугаар биеэс В. Гуравдугаар биеэс

Хариултыг батлах жишээ баримт:

Алхам 3. Өргөдлөөс дараах үг хэллэгийг түүж бичээд дүгнэлт гаргаарай.

Үг хэллэг	Жишээ
Нутгийн аялгууны үг хэллэг	
Нэр томьёо	
Мэргэжлийн үг хэллэг	
Этгээд үг хэллэг	
Уран дүрслэл, далд утгатай үг хэллэг	

Дүгнэлт: Өргөдөлд үг хэллэгийг түлхүү ашигладаг. Учир нь:.....
 үг хэллэгийг бараг ашигладаггүй.
 Учир нь:

Алхам 4. “Өргөдлийг “хүндэтгэсэн”, “гуйсан”, “учирласан” өнгө аясаар бичдэг” гэдгийг батлах жишээг дээрх өргөдлөөс түүж бичээд, шалтгааныг тайлбарлаарай.

А. Хүндэтгэсэн өнгө аяс:

Б. Гуйсан өнгө аяс:

В. Учирласан өнгө аяс:.....

Шалтгаан:.....

Алхам 4. Өргөдлөөс дараах өгүүлбэрүүдийн шалтгааныг бичээд ямар холбох хэрэглүүр ашигласныг тодруулаарай.

1.....

дүү маань ганцаараа сургуульдаа явах, гадаа тоглохоос айдаг болсон.

2.....

.....маш их баярлаж, энэ талаар дэлгэрэнгүй мэдэхийг хүсэж байна.

3.....

.....танай байгууллагаассургалт хийж өгөхийг хүсэж байна.

Дууссан:онсар өдөр..... цаг

--	--	--

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр..... цаг



Хувь хүнээс асуудал шийдэх мэдэл бүхий албан газар, албан тушаалтанд хувийн хүсэлтээ бичин, өргөж барьсан албан бичгийг “өргөдөл” гэнэ. Албаны үг хэллэг ашиглан бичих бөгөөд бичиж байгаа зүйлийн агуулгаас шалтгаалан мэргэжлийн үгс орох нь элбэг. Өргөдлийн хэмжээ, агуулга янз бүр байх боловч өгүүлсэн баримт нь үнэн зөв, дэс дараатай, юу хүссэн тодорхой ойлгомжтой байх нь чухал.

1. Дараах зарлалыг уншаад өгсөн загварт нийцүүлэн өргөдөл бичээрэй.

“Итгэл найдвар хайр” ТББ

Нийгэмд эерэг нөлөө үзүүлэхэд ЕБС-ийн сурагчдын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор сайн дурын ажил хийх сурагчдыг байгууллагатаа гишүүнээр элсүүлэх гэж байна.

Хэрвээ чи манлайлагч залуучуудаас суралцаж, үлгэр дууриалал авч, бусдад туслахыг хүсч байвал бидэнтэй холбогдоорой.

Гишүүнээр элсэх өргөдлийг 2021 оны 10 сарын 31 хүртэл хүлээн авна.

..... –д өргөдөл гаргах нь:

..... овогтой миний бие.....

..... сургуулийн ангид сурдаг.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Өргөдөл гарсан: овогтой

Хаяг:

.....

.....

Утас:

.....оны –р сарын өдөр

--	--	--

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр... цаг



Баримтын алдаа: Тухайн юм үзэгдэл, баримт сэлтийн талаар сайн мэдэхгүй, эсвэл тойм төдий төсөөлөлтэйн улмаас үүссэн алдааг хэлнэ. Уг алдаа нь ихэвчлэн санамсаргүй байдлаас үүсдэг. Мөн цэг таслал, үг үсэг, тоо баримт зэрэг бүх зүйл уг алдаанд хамаарна. **Учирзүйн алдаа:** Сэтгэхүйн хууль, учир шалтгааны хэм хэмжээг зөрчсөнөөс үүссэн алдааг хэлнэ. **Холбох үг буруу хэрэглэсэн алдаа:** Холбох үгс нь салангид өгүүлбэрүүд болон өгүүлбэрийн гишүүдийг холбох үүрэгтэй ай юм. Холбох үгсийг буруу сонгосноос болоод учирзүйн алдаа үүсдэг.

Дасгал 1. Найруулгын алдааг ялган танья.

Алхам 1. Дараах өгүүлбэрийг харьцуулаад, зөв найруулсан өгүүлбэрийг тэмдэглэ.

1. Манай ангийн 40 сурагчийн 50 хувь нь буюу 22 сурагч нь эрэгтэй.	1. Манай ангийн 40 сурагчийн 50 хувь нь буюу 20 сурагч нь эрэгтэй.
2. Манай хамт олон АНУ руу явган аялал хийхээр бэлтгэж байна.	2. Манай хамт олон АНУ руу аялал хийхээр бэлтгэж байна.
3.	

Алхам 2. Дараах найруулгын алдаанд тохирох жишээг дээрх өгүүлбэрээс олж, тайлбарлаарай.

Алдаа	Жишээ өгүүлбэр	Тайлбар
Тоо баримтыг буруу бичсэн.		
Учир зүйн алдаа гаргасан.		
Холбох үг оновчгүй ашигласан.		

Алхам 3. Дараах өгүүлбэрт найруулгын ямар алдаа гарсныг зөв харгалзуулаарай.

1. Ерөнхийлөгч манай улсын хамгийн анхны сансрын нисгэгч Гүррагчааг хүлээн авч уулзлаа.	А. Учир зүйн алдаа
2. ...Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр энэ сарын 27-28-ны өдрүүдэд Хэнтий аймгийн төв Өндөрхаан хотод ажиллалаа. ("Өглөөний сонин" 2008.12.01 №231/554)	
3.	Б. Баримтын алдаа
4. Бээжингийн олимпын галт бамбарыг 14663 хүн хамгаалан дагана. Үүнд аж үйлдвэр бизнесийн 4471, БСШУ-ы 2231, тамирчид 669, тариачин 496, гадаадын 391, сайн дурын 3796 хүн байна.	
5. Хаалттай үзүүлэх тоглолт болно. Өргөнөөр ирж үзнэ үү. (Телевизийн зарлал)	В. Холбох үг буруу
6.	

Дууссан:онсарөдөр... цаг

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг



Баримт- Өргөн утгаар нь үзвэл бодит нөхцөлд үнэхээр болсон, үнэн болохыг нь нотлох боломжоор мэдээлэл/ statement/. **Уран дүрслэл**- Өгүүлж хэлэх гэсэн санаагаа уран дүрслэлтэй, уянга яруу, содон сонирхолтой, далд нууцлаг болгон илэрхийлэх зорилгоор хэлний нөөц боломжийг бүрэн ашиглахыг хэлний дүрслэн илэрхийлэх арга хэрэглүүр гэнэ. Жишээ нь: Адилтгал, хүншүүлэл, төлөөлөл ... гэх мэт олон арга хэрэглүүр бий.

Дасгал 1. Баримт ба дүрслэлийг ялган таних

Алхам 1. Харгалзуулна уу.

Баримт	Өгүүлж хэлэх гэсэн санаагаа ... сонирхолтой илэрхийлэх зорилгоор хэлний нөөц боломжийг бүрэн ашиглахыг хэлний дүрслэн илэрхийлэх арга хэрэглүүр гэнэ
Үзэл бодол, сэтгэгдэл	Өргөн утгаар нь үзвэл бодит нөхцөлд үнэхээр болсон, үнэн болохыг нь нотлох боломжтой мэдээлэл
Уран дүрслэл	Баримт

Алхам 2. Тодорхойлолтыг тохирох уран дүрслэлтэй зөв харгалзуулна уу.

Тодорхойлолт		Уран дүрслэл
Зөвхөн хүнд байдаг онцлог шинж чанарыг амьтан, амьгүй шилжүүлэн дүрслэх хэрэглүүр		Адилтгал
Үгийг үндсэн утгаар нь биш, өөр төстэй үзэгдлийг дүрслэхэд утга шилжүүлэх дүрслэх хэрэглүүр		Төлөөлөл
Нэгийг нөгөөгөөр орлуулан утга шилжүүлэн дүрслэх хэрэглүүр		Хүншүүлэл



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг

Алхам 3. Онъсогод ямар уран дүрслэл ашигласан байна вэ? /Адилтгал, амьдчилал, төлөөлөл/

Наран доогуур намирч байх юм
 Навч цэцэг **шиг** нахилзаж байх юм
 Бөжин туулай **шиг** бүгж байх юм
 Бөөр зүрх шиг догдолж байх **шиг** юм

/Хамхуул хийсэх/

Түмэн **хонь нь бэлчээд** явахад
 Түнтгэр **хуц нь унтаад** хоцорно.

/Хээр хоносон сар/

Уушгин эмгэн ирээд
 Улаан халзан болоод буцав

/Хэт цахих/

Дасгал 2. Баримт, үзэл бодол, уран дүрслэлийг ялган таних

Алхам 1. Өгүүлбэрийг уншаад, аль нь баримт, аль нь үзэл бодол болохыг ялгаж, тохирорх нүдэнд тэмдэглэнэ үү.

	Баримт	Үзэл бодол
Ус 100 градуст буцалдаг.		
Голын хүйтэн усанд орох нь эрүүл мэндэд сайн.		
Тогоруу бол нүүдлийн шувуу.		
Тогоруу төмөр дөрөө сэтэртэл хараадаг.		
Дэлхий нарыг 365 хоногт нэг удаа тойрдог.		
Өглөөний нарыг наранд бүү бод Өсөхийн жаргалыг жаргалд бүү бод		
1206 онд Чингис хаан Монголын эзэнт гүрнийг байгуулсан.		

Алхам 2. Өгүүлбэрээс уран дүрслэлийг олж, бүтсэн аргыг нь товч тайлбарлаарай.

	Уран дүрслэл	Тайлбар
Газрын өндөр оргилоос Хөх усан могой гарч Гадаад их далайд Шунган орж наадахад ... /ЦД/	төлөөлөл	Усны мурилзан урсахыг могойн хөдөлгөөнөөр төлөөлүүлсэн.
Үдийн халуунд ус руу давхих Олон адууны замд Үнс хөх тогорууны өндөг Цайран үлдсэнийг үзлээ.	адилтгал	
Насан багадаа нэгэн өглөө Нарыг хараад их ажсан юм Нар тэгэхэд нэг л сайхан Намайг хараад инээж байсан юм	хүншүүлэл	
Одтой тэнгэр орчиж Олон улс байлдаж Орондоо унтах завгүй Олзлолдон тэмцэж	адилтгал	

Дууссан:онсарөдөр..... цаг



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг

Алхам 1. Хоёр эхийг уншиж, ойлгоорой.**Төв Азийн минж**

Минж өөрийн амьдрах орчиндоо амрах хэвтэх, муу нүх, овоохой, далан зэрэг хэд хэдэн төрлийн хоргодох байрыг бий болгодог.

Голын гүн устай, өндөр эрэгтэй газар нүх ухаж овоохой засна. Нүхний ам усны гүнд. Нүхэнд агаар оруулах салхивч өрхтэй. Овоохойн хэмжээ бүлийн тооноос хамаарч харилцан адилгүй байна. Нэг бүлд эр, эмэгчин тухайн жилийн үр төл хамт амьдарна. Эзэмшил нутгийнхаа захад шороо овоолон заараараа тэмдэг тавина.

Овоохойн урт өргөн 6×4 метр орчим, өндөр нэг метр, ханын зузаан 20-30 см орчим хэмжээтэй байна. Овоохойг бүдүүвтэр мод босгон модны мөчир болон бусад ургамлын иш мөчрөөр барьж, шавардаж нягтруулсаар бат бэх болгосон байдаг.

Даланг голдуу ус багатай жижгэвтэр голд барих бөгөөд хамгийн хялбар далан гэхэд л 1-2 метр урттай байна. Далан гэж минжнүүд голын урсгал, салаа, татуургад бүдүүн мод, модны мөчрүүдийг богинохон мэрж таслан усны урсгалд хөндөлдүүлэн, давхарлан овоолж, гарсан зай завсрыг голын шавар, мод, чулуугаар бэхжүүлж барьсан зүйлийг хэлнэ.

Минж бол өвсөн тэжээлтэн. Бургас, улиас, улиангар зэрэг модлог ургамлууд, улалж, цагаан бөмбөө, жагмаа зэгс зэрэг усны ургамлууд, нийт 300 гаруй зүйлийн модлог болон өвслөг ургамлаар хооллодог.

*Нийслэлийн байгаль орчны газар**Биологийн олон янз байдлыг хамгаалах, минж нутагшуулах хэлтэс***Минж бодож сэтгэдэг байж магадгүй**

(Хэсэглэн авав)

Минж бол өдөр огт харагддаггүй амьтан. Усан доогуур байдаг нүх рүүгээ шургаад орчихно. Нүхний нь ам голын усан дор байрладаг гээд бодохоор айхавтар нууцлагдаж байгаа биз. Гэвч түүний ул мөр их бий. Яагаад гэвэл тэр тун хөдөлмөрч амьтан тул газар дээр босгосон бүтээсэн нь зөндөө. Суваг татаж, далан барьж, овоохой босгодог. Энэ тухай товч тайлбарлая.

Булган голын минж овоохойгоо улиас бургас модоор барина. Яндангийн чинээ модыг тас мэрж унагана. Шүд нь хурц. Унагасан модоо зөөхийн тулд суваг татна. Газраар чирж байснаас усаар хөвүүлэх нь хамаагүй амар. Модыг зөрүүлэн босгож, мөчрөөр сүлжин бэхэлж, хаяаг нь шавардан битүүлдэг байна. Морины хусуур хэлбэрийн хавтгай сүүл нь нийвий болдог аж. Овоохой босгож байгаа нь энэ. Овоохойнуудтой тохой байнга устай байх ёстой. Тийм байлгахын тулд далан барина. Модыг хөндлөн унаган давхарлаж шороо, чулуугаар чигжиж бэхэлнэ.

Минжнүүд өөр өөрийн цөөрөмдөө хөвж, идэш тэжээлээ цуглуулан тавтайхан хооллоно. Навч, холтос, намгийн ургамал, цахилдаг, зэгс, усны өвс иддэг байна. Өвөлд бэлдэж мөчир, навч нөөцөлнө.



Ж.Мягмарсүрэн “Унагаа зуусан хулан”



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг

Алхам 2. Хоёр эхэд хамгийн олон давтагдсан үг буюу түлхүүр үгийг олоорой.

Төв азийн минж		Минж бодож сэтгэдэг байж магадгүй.
		

Алхам 2. Хоёр эхээс тохирох 1-2 жишээ олж, тохирох хэсэгт бичээрэй.

	Төв Азийн минж	Минж бодож сэтгэдэг байж магадгүй
Эхэд өгүүлсэн зүйл		
Эхэд ашигласан баримт		
Эхэд ашигласан уран дүрслэл		
Бичигчийн сэтгэл хөдлөлөө илэрхийлсэн хэсэг		
Зохиогчийн үзэл бодлоо илэрхийлсэн хэсэг		
Эхийн найруулгын төрөл, хэв маяг		
ДҮГНЭЛТ	<input type="radio"/> Уран сайхны эх мөн <input type="radio"/> Уран сайхны эх биш	<input type="radio"/> Уран сайхны эх мөн <input type="radio"/> Уран сайхны эх биш
Уран сайхны эх мөн, биш гэж дүгнэснээ тайлбарлаж 1-2 өгүүлбэрээр бичээрэй.		



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг

Алхам 3. Хоёр эхэд минжний шүдийг дүрсэлсэн хэсгийг сонгож, ижил ба ялгаатай тал болон дүгнэн бичсэн байгаа. Эдгээрийг ажиглаарай.

Минж нь том, хүчирхэг үүдэн шүдээрээ мод, ургамлыг мэрг тасдан хоол хүнс болон далан, үүр барих материал бэлддэг. 15 см голчтой модыг шүдээрээ мэрг, 10 минутад унагадаг байна.

Яндангийн чинээ модыг тас мэрг унагана. Шүд нь хурц. Унагасан модоо зөөхийн тулд суваг татна.

	Төв Азийн минж	Минж бодож сэтгэдэг байж магадгүй
Ижил тал /Юуны тухай өгүүлсэн бэ?/	Хоёр эхэд минжний шүдний гүйцэтгэдэг үүргийг өгүүлжээ.	
Ялгаатай тал /Юуг яаж дүрсэлсэн бэ?/	15 см голчтой модыг 10 минутад унагадаг байна.	Яндангийн чинээ модыг тас мэрг унагана.

Дүгнэсэн нь:

Хоёр өгүүлбэрт минжний идэх хоолоо олох, амьдрах оромж, хамгаалах далан барихад шүд нь гол багаж /зэвсэг/ болдог тухай өгүүлжээ. А эхэд минж “...15 см голчтой модыг мэрг 10 минутад унагадаг” гэсэн баримт ашигласан бол Б өгүүлбэрт “Яндангийн чинээ модыг тас мэрг унагана.” гэж модны диаметрийг яндантай зүйрлэсэн бол шүднийх нь хурцыг “тас мэрг унагана” гэжээ.

Алхам 4. Хоёр эх дэх минжний овоохойн ижил ба ялгаатай талыг хүснэгтэд бичээд дүгнэж бичээрэй. Алхам 3-ын дарааллаар

А Овоохойн урт өргөн 6×4 метр орчим, өндөр нэг метр, ханын зузаан 20-30 см орчим хэмжээтэй байна. Овоохойг бүдүүвтэр мод босгон модны мөчир болон бусад ургамлын иш мөчрөөр барьж, шавардаж нягтруулсаар бат бэх болгосон байдаг. Үргэж цочиж усанд шумбахдаа өргөн хавтгай сүүлээрээ чанга ус алгадаж бусдадаа дохио өгдөг аж.

Б. Модыг зөрүүлэн босгож, мөчрөөр сүлжин бэхэлж, хаяаг нь шавардан битүүлдэг байна. Морины хусуур хэлбэрийн хавтгай сүүл нь нийвий болдог аж. **Овоохой босгож байгаа нь энэ.**

	Төв Азийн минж	Минж бодож сэтгэдэг байж магадгүй
Ижил тал /Юуны тухай өгүүлсэн бэ?/		
Ялгаатай тал /Юуг яаж дүрсэлсэн бэ?/		



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг

Дүгнэсэн нь:

.....

.....

.....

.....

.....

.....

А. Минж бол өвсөн тэжээлтэн. Бургас, улиас, улиангар зэрэг модлог ургамлууд, улалж, цагаан бөмбөө, жагмаа зэгс, зэрэг усны ургамлууд нийт 300 гаруй зүйлийн модлог болон өвслөг ургамлаар хооллодог.

Б. Минжнүүд өөр өөрийн цөөрөмдөө хөвж, идэш тэжээлээ цуглуулан тавтайхан хооллоно. Навч, холтос, намгийн ургамал, цахилдаг, зэгс, усны өвс иддэг байна. Өвөлд бэлдэж мөчир, навч нөөцөлнө.

	Төв Азийн минж	Минж бодож сэтгэдэг байж магадгүй
Ижил тал /Юуны тухай өгүүлсэн бэ?/		
Ялгаатай тал /Юуг яаж дүрсэлсэн бэ?/		

Дүгнэсэн нь:

.....

.....

.....

.....

.....

.....

.....

--	--	--

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг

Дүгнэсэн нь:

.....

.....

.....

.....

.....

А. Минж бол өвсөн тэжээлтэн. Бургас, улиас, улиангар зэрэг модлог ургамлууд, улалж, цагаан бөмбөө, жагмаа зэгс, зэрэг усны ургамлууд нийт 300 гаруй зүйлийн модлог болон өвслөг ургамлаар хооллодог.

Б. Минжнүүд өөр өөрийн цөөрөмдөө хөвж, идэш тэжээлээ цуглуулан тавтайхан хооллоно. Навч, холтос, намгийн ургамал, цахилдаг, зэгс, усны өвс иддэг байна. Өвөлд бэлдэж мөчир, навч нөөцөлнө.

	Төв Азийн минж	Минж бодож сэтгэдэг байж магадгүй
Ижил тал /Юуны тухай өгүүлсэн бэ?/		
Ялгаатай тал /Юуг яаж дүрсэлсэн бэ?/		

Дүгнэсэн нь:

.....

.....

.....

.....

.....

.....

.....

--	--	--

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг



Зөвлөгөөг дэс дараатай тоочсон байдлаар бичдэг. Тухайн зөвлөгөөг итгэл үнэмшилтэй, ойлгомжтой болгох зорилгоор учир шалтгааныг тайлбарлан бичнэ. Зөвхөн би байсан бол гэж өөрийн өнцгөөр үзэл бодлоо тулгалгүй тухайн асуудлыг шийдэх боломжтой хэд хэдэн хувилбар санал болгож бичвэл сайн.

Дасгал 1. Учир шалтгааныг тайлбарласан зөвлөгөө өгье. Зөвлөхдөө дараах 3 талаас харж учир шалтгааныг нь тайлбарлаж бичээрэй.

1. Хэрвээ би чиний оронд байсан бол -х байсан. Учир нь
2. Чиний хувьд –сэн нь дээр байх. Яагаад гэвэл.....
3. Яагаад -ж болохгүй гэж.

Асуудал	Чиний өгөх зөвлөгөө
Миний нүүрэн дээр байнга батга гарах болсон. Толинд харах болгондоо сэтгэлээр унах боллоо. Яаж энэ батганаас салах вэ? Надад туслаач	1. Би чиний оронд байсан бол өөх тос ихтэй хоол хүнсээ багасгах байсан. Учир нь арьсны асуудлууд ихэнхдээ хоол хүнснээс болдог.
	2. Гэхдээ чиний хувьд сэтгэлээр унаж, стрессдэхээ болих хэрэгтэй. Учир нь стресс хүнийг маш их ядрааж улмаар арьсны тэнцвэрт байдал алдагдаг гэж сонссон.
	3. Арьс гоо заслын эмнэлэгт хандаж яагаад болохгүй гэж. Харин ч асуудлыг нь тодорхойлоод тохирох бүтээгдэхүүн зөвлөх байх гэж бодож байна.
Би боксоор хичээллэхийг маш их хүсдэг. Даанч аав ээж маань чиний ирээдүйд бокс хэрэг болохгүй. Тэрний оронд хуульч болсон нь дээр гээд зөвшөөрөхгүй байна. Яавал дээр вэ?	1.
	2.
	3.
Удахгүй сайн найзын маань төрсөн өдөр болно. Би найздаа гэнэтийн бэлэг барьж баярлуулмаар байна. Яавал найз маань баярлах бол? Ямар санаа байна?	1.
	2.
	3.

Дууссан:онсарөдөр..... цаг

Сурагчийн нэр: тодорхойлъё. Эхэлсэн: он сар өдөр цаг



Хоёр бие даасан үг зэрэгцэх ба угсрах харьцаагаар нийлж үг бүтээх аргыг **үг нийлэх арга** гэнэ. Энэ аргаар бүтсэн үгийг **нийлмэл үг** гэнэ.

Нийлмэл үгийг зэрэгцсэн ба угсарсан нийлмэл үг гэж ангилна. Хоёр үгийн нэг угсран захирагдаж бүтсэн үгийг **угсарсан нийлмэл үг** гэнэ. Угсарсан нийлмэл үг зар холбогдож бүтнэ.

1. Нэг үг нь нөгөөдөө үндсээрээ холбогдож хамжсан угсраа үг бүтнэ. Жишээ нь: мөнгөн ус, гар бөмбөг, бор гөрөөс, улаан ном гэх мэт
2. Хоёр үг хоорондоо нэрийн ба үйлийн холбох нөхцөлөөр холбогдож найрсан угсраа үг бүтнэ. Жишээ нь: эдийн засаг, усны үхэр, сөдийн толгой, чонын элэг гэх мэт

Дасгал 1. Угсарсан нийлмэл үгийг таньж, хэрэглэе.

Хөвсгөл нуур

Хөвсгөл гэдэг үг нь түрэг хэлээр *Көл Су Кул* буюу "Их Устай Нуур" гэсэн үг юм. Монголчууд эрт дээр үеэс **Ариг ус** хэмээн нэрлэж байжээ. Хөвсгөл нуур нь Саяны нурууны зүүн хэсэгт байрлана. Өмнөд хэсэгт Эгийн гол эх авах бөгөөд Сэлэнгэ мөрөн, цаашлаад Байгаль нууртай холбогдоно.

Долоон уул, Модотын шанаа, Салаа сарьдаг, Мэргэний үзүүр, Агьтын хошуу, Дээд, Доод модот булан, Марааны булан зэрэг нуурт түрж орсон хагас арал булантай. Модон хүй, Хадан хүй, Хүй толгой, Сома хад гэсэн 4 аралтай.

Хөвсгөл нуурын ай сав, Хорьдол Сарьдагийн нуруунд Монголын Улаан номд орсон нэн ховор амьтан болох цоохор ирвэс, баданга хүдэр, зэрлэг цаа буга, ховор амьтан болох хүрэн баавгай, халиун буга, янгир ямаа, аргаль хонь, бараан хандгай, ойн булга зэрэг хөхтөн амьтад амьдардаг. Мөн умардын халиу, бор гөрөөс, зэрлэг гахай, нохой зээх, тарвага, чандага, чоно, үнэг, хярс, мануул, дорго, зурам, хэрэм, солонго, цагаан үе, өмхий хүрнэ, шилүүс, алаг даага зэрэг амьтад байдаг.

Алхам 1. Дараах нийлмэл үгсээс угсарсан нийлмэл үгийг ялган будаарай.

Хөвсгөл нуур

Саяны нуруу

зүүн хэсэг

Ариг ус

Түрэг хэл

Алхам 2. Угсрах аргаар бүтсэн амьтны нэрсийг түүж бичээрэй.

.....

.....

Алхам 3. Угсрах аргаар бүтсэн арал болон булангийн нэрийг холбосон аргаар нь ангилж бичээрэй.

Хамжсан угсраа үг	Найрсан угсраа үг
• Долоон уул	• Модотын шанаа
•	•
•	•
•	•
•	•
•	•

Алхам 4. Дараах 2 бүлэг үгсийн утгыг ажиглаад ялгааг тайлбарлаарай.

1. Улаан ном, Модон хүй, Модотын шанаа, алаг даага
2. Долоон уул, цоохор ирвэс, бор гөрөөс, Дээд модот

Тайлбар:

Дууссан:онсарөдөр..... цаг



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг



Хоёр өгүүлбэрийн эхний өгүүлбэрийн үйл явдал нь дараагийн үйл явдал бүтэхийн үндэс болж төгс бус өгүүлэхүүнээр илэрсэн өгүүлбэрийг шалтгааны утгатай өгүүлбэр гэнэ. Ийм өгүүлбэр нь яагаад?, ямар учраас?, юуны учир?, юуны тул?, яавал?, яаснаас? гэх зэрэг асуултад хариулагдана.

Дасгал 1. Шалтгааны утгат угсарсан нийлмэл өгүүлбэрийг задлан шинжилье.

Алхам 1. Дараах нийлмэл өгүүлбэрийг энгийн өгүүлбэр болгон бичээрэй. Жишээлбэл:

Ах хотруу явснаас манайх нүүж чадсангүй.

а. Ах хот руу явсан.

б. Манайх нүүж чадсангүй

1. Хичээлээ уншаагүй учраас хангалгүй шалгагдлаа.

а.

б.

2. Багаасаа хөдөө өвөөгийн дөвөө өссөн тул сүү цагаан идээ идэх дуртай.

а.

б.

3. Олон жил найзалж байгаа болохоор бие биенийхээ занг андахгүй.

а.

б.

Алхам 2. Дараах өгүүлбэрүүдийг шалтгааны утгат холбох хэрэглүүр ашиглан холбож бичээрэй.

учраас, тул, улмаас, учир, бол, -тал4, -вал4, -нгуут2, -нгаа4

1. Бороо их орсны томоохон голууд эргээсээ хальжээ.

2. Өглөө бүр 30 минут ном уншдаг мэдлэгийн хүрээгээ тэлж чадаж байна.

3. Гадаадад сурахыг хүсдэг англи хэлээ сайжруулахаар хичээж байна.

Алхам 3. Дараах өгүүлбэрийг гүйцээж шалтгааны утгат угсарсан нийлмэл өгүүлбэр бүтээгээрэй.

1. тул болзсон цагтаа амжсангүй.

2. учир гавьяат багш цол хүртлээ.

3. Амттанд маш их дуртай

4. Монгол улс байгалийн баялаг ихтэй

5. Алхам 4. Дараах өгүүлбэрээс шалтгааны утгат угсарсан нийлмэл өгүүлбэрийг олж дугуйлаад, шалтгааны утгат холбох хэрэглүүрийг нь тэмдэглээрэй..

а) Шувууд хоол тэжээлээ олж идэхийн тулд нүүдэллэдэг.

б) Эх нь булингартай бол адаг нь булингартай.

с) Идэр нас хөгшрөхийн өмнө их хэргийг бүтээх нь сайн.

д) Өвөл жижиг амьтдад хоол тэжээл хомс байдаг учраас зун намрын цагт идэш тэжээлээ нөөцөлдөг.

Алхам 5. Дараах хэсэгт шалтгааны утгатай угсарсан нийлмэл өгүүлбэр 2-ыг зохиож бичээрэй.

1.

2. Дууссан: он сар өдөр цаг



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг



Учир шалтгааны утгатай өгүүлбэр- Эхний өгүүлбэр нь дараагийн өгүүлбэр бүтэхийн үндэс болж, төгс бус өгүүлэхүүнээр илэрсэн өгүүлбэрийг шалтгааны утгатай нийлмэл өгүүлбэр гэнэ. Ийм өгүүлбэр нь юуны учир, ямар учраас, яагаад, яахлаар, яаж, яаснаас, яасанд юу гэж, юуны тул зэрэг асуултад хариулагдана. Үг: учраас, тул, тулд, учир, улмаас, нгаа, бол
Нөхцөл: -тал4, -бал4, -вал, нгуут2, -нгаа4, -аад4

Дасгал 1. Өгүүлбэрийг утгаар нь задалж, учир шалтгааны утгатай өгүүлбэрийг таньж олох

Алхам 1. Учир шалтгааны утгатай өгүүлбэрийг олно уу

- | | |
|---|--|
| А. Эрт босвол нэгийг үзнэ
Орой унтвал нэгийг сонсоно. | В. Хялмаа ихэдвэл зуд болно
Хялар ихэдвэл сохор болно |
| Б. Хог новшгүй бол гэр цэвэр
Хэрүүл шуугиангүй бол сэтгэл амар | Г. Уулын бугыг хараад
Унасан морио хаях |

Алхам 2. Учир шалтгааны утгатай нийлмэл өгүүлбэрийг энгийн өгүүлбэр болгон задалж бичээрэй.

Нийлмэл өгүүлбэр	Шалтгаан	Үр дагавар
Олон төрлийн хоол хүнсийг сольж хэрэглэх нь хүний биед шаардлагатай уураг, амин дэм, нүүрс усыг зохистой хэмжээгээр авахад тустай.	Хүний биед шаардлагатай уураг, амин дэм, нүүрс усыг зохистой хэмжээгээр авахад	Олон төрлийн хоол хүнсийг сольж хэрэглэх нь тустай
Бүтэн үр тариа бүхий хүнсний бүтээгдэхүүнд хүний биед шаардлагатай шим тэжээлт бодис илүү агуулдаг тул түлхүү хэрэглэвэл зохино.		
Өөх тосыг хэтрүүлэн хэрэглэвэл жин нэмэгдэхээс гадна зүрх судасны өвчин, даралт ихсэх зэрэг өвчин үүсгэдэг.		
Чихэрлэг зүйлийг байнга хэрэглэснээс шүд хорхойтож, зарим хүний жин нэмэгддэг.		
Долоо хоногийн мах, хиамны хэрэглээ нь 600 граммаас илүүгүй байх нь зохистой, учир нь мах нь бие махбодод төмөр, эрдэс бодис, амин дэм (В1, В6, В12) өгдөг.		
Ус бол амьдралын чухал хэрэгцээ тул хүн өдөрт наад зах нь 1,5 литр шингэн зүйл уугаарай.		



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг

Алхам 3. Өгүүлбэрээс шалтгааны утгатай үг, нөхцөлөөс тохирохыг нөхөж бич.

1. Уулын чулуу уна ... уруугаа хол өнхөрнө.
Улсын тэргүүн алд ... учрах ял хүндэрнэ /ДО/
2. Хашийг эс зас ... сав болохгүй
Хүнийг эс зас ... ёс мэдэхгүй /Ардын үг/
3. Залуус минь, бага мэддэгээ ухаарахын чиг маш их суралцах хэрэгтэй!
/Монтень/
4. Хийж чаддаг зүйлээ байнга хий... хэзээ ч өсөхгүй. Харин хийж чаддаггүй зүйлсээ
..... та өснө. /Осборн/ /хийж байж/
5. Бусдыг сонс..... дуугүй байна гэдэг ухаан сууж буйн шинж. Мэргэн ухааны дээд нь
нам гүмд оршдог. /Пифагор/ /-оод/
6. Онч үгсийг хэрэглэ.... үг цөөн, утга агуу болно. /Марк Твен/
7. Нэр хүнээ алдахгүйн зарим доромжлолыг чимээгүй залгичих нь дээр. /Вовенарг/
/тулд/
8. Тайван цагт хөлс их гарах юм байлдааны цагт цус бага гарна /С.Над/ /-бол/

Дасгал 2. Учир шалтгааны утгатай өгүүлбэрийг найруулж найруулж бичих

Алхам 1. Дараах хоёр өгүүлбэрийг шалтгааны утгатай үг, нөхцөлөөр холбож найруулна уу.

- Тамхи нь их хэмжээгээр шүлс ялгаруулдаг. Тамхичин хүн байнга шүлсээ хаяж, гудамж талбайг бохирдуулаг.
.....
.....
- Тамхичин хүний уушгины багтааж эрүүл хүнээс 20 хувь бага байдаг. Тамхи нь амьсгалдын замын торлог, сүлжээсэн эд, эсийг гэмтээдэг. Тамхи нь агаар сорох боломжийг багасгадаг.
.....
.....
- Тамхинд байдаг никотон хэмээх бодис донтуулдаг үйлчилгээтэй. Тамхинд нэг орчихвол түүнээс гарахад амаргүй байдаг.
.....
.....

Дууссан:онсарөдөр..... цаг

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг

- Зарим охид жингээ барих гэж тамхи татдаг. Тамхи, гоолиг бие хоёр хоорондоо ямар ч холбоогүй болохыг судлаачид тогтоожээ.

.....
.....

- Тамхичны дэргэд байгаа илүү их хорддог. Тамхины утаа нь тамхичдын шууд амьсгалж буй утаанаас олон төрлийн хорын агууламжаар өндөр байдаг билээ.

.....
.....

- Зарим хүн тамхины хор уршгийг мэддэггүй, тамхины хорыг дутуу үнэлдэг. Зарим нь тамхи татахаар тайвширдаг, бухимдлаас салах нэг арга гэж боддог. Тамхи татдаг.

.....
.....

- Зарим охид жингээ барих гэж тамхи татдаг. Тамхи, гоолиг бие хоёр хоорондоо ямар ч холбоогүй болохыг судлаачид тогтоожээ.

.....
.....

Дасгал 3. Учир шалтгааны утгатай өгүүлбэрийг тонгоргон найруулж найруулж бичих

Жишээ нь: Бодож сэтгэх нь бяр чадлын ундарга тул түүнд цаг гарга.

Тонгоргон найруулсан нь: Бодож сэтгэхэд цаг гарга, учир нь энэ бол бяр чадлын ундарга.

1. Хүнсний бүтээгдэхүүн нь гэрэл, хүчилтөрөгч, халуун, усанд амархан муудах талтай.

.....
.....

2. Хүнсний материалыг удаан хадгалж болохгүй, болж өгвөл шинээр нь хэрэглэх хэрэгтэй.

.....
.....

3. Яарч, эсвэл юм хийнгээ хооллоход амтыг нь мэдэрч таашаал авч чаддаггүй.

.....
.....

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг

Дасгал 1. Өргөдлийн агуулга, бүтцийн тухай ойлголтоо бататгая.

Алхам 1. Өргөдлийн агуулгыг бүтцээр нь зөв харгалзvvлаарай.

Өргөдлийн толгой буюу эхлэл хэсэг

Өргөдлийн үндсэн агуулга гол хэсэгт

Өргөдлийн төгсгөл хэсэг

Өргөдөл гаргах болсон шалтгаан

Өргөдөл гаргагчийн нэр, хаяг утас

Байгууллага, албан тушаалтны нэр

Өргөдөл гаргагчийн товч танилцуулга

Өргөдөл гаргасан он, сар, өдөр

Юуг яаж шийдvvлэхээр хүсэж байгаа

Алхам 2. Өргөдөл гаргах болсон учир шалтгааныг тодорхой тайлбарлан бичих нь ямар ач холбогдолтой вэ?

.....

.....

Дасгал 2. Зөвлөгөө бичих тухай ойлголтоо нэгтгэе.

Анхаарах зүйл	Чухал	Чухал биш	Яагаад?
Үзэл бодлоо тулгахгүй, санал болгосон, зөвлөсөн байдлаар бичих			
Өөрийн санаагаа зөв гэдгийг маш сайн ойлгуулж, ятгах			
Зөвлөж буй хүнийхээ нөхцөл байдлыг сайтар бодох			
Яагаад ингэж зөвлөх болсон шалтгаанаа тодорхой тайлбарлаж бичих			

Алхам 2. Дараах өгүүлбэрүүдийг гүйцээн бичиж, шалтгааны утгат угсарсан нийлмэл өгүүлбэр бүтээгээрэй.

- өглөө эрт босох нь ашигтай.
- Нүдний хараанд сайн
- англи хэл сурах хэрэгтэй.
- Өвөл цас их орсон